

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”
ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
/2021-2023 он/

2023 оны 09 дүгээр сарын байдааар/

2023 оны 08 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх Ү/СВЭР(САЯ ТӨРӨГ)ЕССӨН	Зорилтот тувшин, ур дунгийн үзүүлэлт	Хүрсэн тувшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний тайлбар	Хариуцах байгууллага
---	-----------------	-------------	------------------	------------------	--	--	-----------------------	-------------------	--------------------	-------------------------

5. ТАВ. ЗАСАГЛАЛ

1.	5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	2021-2025	-	-	34	Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд 2020 онд нэвтрүүлж, 2021 онд баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан. Тус газар нь 9 тэргүүлэх аудитор, 17 дотоод аудиторыг бэлтгэн гэрчилгээжүүлснээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг зөвлөмж, арга зүйгээр хангах, хамтран ажиллах боломж бүрдсэн. - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, хэлтэс нэгжийн дарга наарт зориулсан "Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн" сэдэвт сургалтыг 2021 онд зохион байгуулж 130 гаруй албан хаагчдыг хамруулсан. - Байгууллагын хэмжээнд чанарын удирдлагын тогтолцооны дотоод аудитын	70		НЗДТГ ХСХГ
----	--	---	-----------	---	---	----	--	----	--	------------

							үйл ажиллагааг жил бүр удирдамж, төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах 70 гаруй зөвлөмж боловсруулан хүргүүлж, үйл ажиллагааны чанар, гүйцэтгэлийг сайжруулан ажиллалаа. - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд 2023 онд нийт 20 байгууллагын дэд ажлын хэсэгт тус газрын 5 албан хаагчид ажиллаж, мэргэжил арга зүйгээр ханганд ажлын гүйцэтгэлд хяналт тавин хамтран ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

8. НАЙМ. БУС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

2.	8.1. Монгол улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул хая хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлж, хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна.	8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021-2025	-	-	1	Үндэсний хэмжээнд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд Улаанбаатар хотод хог хаягдал булах, мах, суүний чиглэлийн үхрийн аж ахуйн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсдэг метаны хий, нүүрс хүчлийн давхар исэл, азотын дутуу исэл ялгаруулж, сөрөг нөлөө үзүүлж байгаа тул хотоос гаргах шаардлагатай талаар санал боловсруулж, 2021.05.13-ны 01-06/151 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 2023 онд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, аж үйлдвэрүүдийг хотоос шилжүүлэх бүтээн байгуулалтын дараах томоохон төслийдэд хяналтын чиглэлээр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газартай хамтран ажиллаж байна. Үүнд: - Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл,	50	НХБХГ НМХГ НШҮҮ ИГ ХСХГ
----	--	--	-----------	---	---	---	---	----	-------------------------------------

- Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн зураг төсөл

9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ										
3.	9.3 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд сууриссан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	2021-2025	-	-	1	Mонгол улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар “Шил” ажиллагааны хүрээнд барилга, байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын нийт 1739 дүгнэлт, холбогдох мэдээллийг нэгтгэж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэн info@shilen.gov.mn -д байршуулсан. Мөн байгууллагын албан ёсны цахим веб хуудас https://standard.ub.gov.mn/ -д ашиглалтад оруулж буй барилга байгууламжийн орон зайн мэдээллийн сан бүрдүүлж, дашбоард хөгжүүлэлт хийв. Тус мэдээллийн сан нь ашиглалтад орсон орон сууц, олон нийтийн барилгын мэдээллийг барилгын төрөл, ангилал, байршил, захиалагч, гүйцэтгэгч, комиссын дүгнэлт гэх мэт 13-н үзүүлэлтээр мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж байна.	90	-	НХБХГ НГЗБА ХСХГ НМТГ
4	9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	9.5.1 Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгын стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгоно.	2021-2025			Хот төлөвлөх, байгуулах стандарт 45, Төрийн болон нийгмийн үйлчилгээн ий барилга 213	Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангудлах, хотын стандартын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд 2020-2021 онд 22 бүлгийн 97 хотын стандартын төсөл боловсруулсан. Үүнээс 2022 онд 9 бүлгийн 38, 2023 онд 7 бүлгийн 14 хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, 2023 оны А/242 дугаар захирамжаар стандарт, нормыг мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг	90	-	ХСХГ

						батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:				
5	9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.	2021-2025	-	-		<ul style="list-style-type: none"> - Хотын стандартын талаарх 34 удаагийн сургалтад 5264 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулав. - Нийслэлд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын 1641 төсөл арга хэмжээнд стандарт, нормыг мөрдүүлэх талаар хэрэгжүүлэх талаар зөвлөн тусалж, газар дээр нь арга зүйгээр хангасан. - Хяналт шалгалтын хүрээнд барилгын чанар, стандартын хэрэгжилтийг хангуулах, аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 197 аж ахуйн нэгж байгууллагын барилга угсралтын ажилд хяналт шалгалт хийж, улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж 117, зөрчил арилгуулах тухай мэдэгдэл 66, дутагдал арилгуулах албан шаардлага 17 хүргүүлсэн. Мөн орчны аюулгүй байдлыг алдагдуулсан 10 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоож ажилласан. 	2021-2023 онуудад Нийслэлийн иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах зорилгоор "Орчны аюулгүй байдлын судалгаа"-ны ажлыг нийт 34 чиглэлээр зохион байгуулж 10532 зөрчил илрүүлсэн. Дээрх судалгаанд үндэслэн иргэдийн амьдрах орчныг сайжруулж, эрсдэлийг бууруулах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Барилгын гадна түр хашааг 313 байршилд стандартад нийцүүлэв. - Иргэдийн ая тухтай орчинд сэргөөр нөлөөлсөн, орц гарц хаасан, өнгө 	90	-	ХСХГ

						<p>үзэмжгүй 235 байршилд хашаа, хайсыг буулгаж, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн.</p> <ul style="list-style-type: none"> - Ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдал алдагдсан 491 байршилаас 200 байршилд газар дээр нь засварлан зөрчлийг арилгуулав. - Хүүхдийн тоглоомын талбайн стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй нөхцөл үүссэн 419 байршилыг тогтоон 120 байршилд зөрчлийг арилгуулав. - Барилгын ажлын явцад орчны аюулгүй байдлыг хангуулаагүй, стандарт, норм зөрчсөн 95 барилгын ажлын зөвшөөрөл, газрын эрх цуцлуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв. - Барилга, дэд бүтцийн хяналтын чиглэлээр эрсдэл учруулж болзошгүй зөрчлийг илрүүлж, улсын /ахлах/ байцаагчийн 401 мэдэгдэл, 113 зөвлөмж, 123 дүгнэлт, 162 албан шаардлага хүргүүлж, зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг 123 иргэн, аж ахуйн нэгжид явуулж 203.3 сая төгрөгийн тorgуулийн арга хэмжээ авч ажиллав. 		
--	--	--	--	--	--	---	--	--

Дундаж биелэлт: 78%

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Э.ДАВААХАТАН

Г.ЭНХЭЭ

М.ГАЧМАА

9022090260-8314551